

**“Сайн” хэмээх ойлголт илэрхийлсэн монгол зүйр цэцэн үгсийг
Гартманы аксеологийн онцлогийн үүднээс
задлан шинжлэх нь**

Цэндээхүүгийн Эрдэнэбат 

*Монгол Улсын Боловсролын Их сургуулийн Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн
багш, доктор (Ph.D), Монгол Улс, Улаанбаатар*

Банзрагчийн Пүрэвсүрэн 

*Монгол Улсын Боловсролын Их сургуулийн Нийгэм Хүмүүнлэгийн Ухааны Сургуулийн Англи хэлний тэнхимийн багш,
докторант, Монгол Улс, Улаанбаатар*

Хүлээн авсан - Received:
2025-04-09

Засварласан - Revised:
2025-04-20

Хэвлэгдсэн - Published:
2025-06-10

Erdenebat.ts@msue.edu.mn

ORCID: [0009-0006-4676-3515](https://orcid.org/0009-0006-4676-3515)

b.purevsuren@msue.edu.mn

ORCID: [0009-0000-0492-1577](https://orcid.org/0009-0000-0492-1577)

Corresponding author:
Purevsuren Banzragch



© 2025, Author(s)

Хураангуй: Улс үндэстний сэтгэлгээний онцлог, соёлыг судлах боломж, талбар бол тухайн ард түмний аман зохиол, зүйр цэцэн үгс, үлгэр домог юм. Зүйр цэцэн үгсийн утга зүйн судалгаа олон байдаг боловч үнэлэмжийн талаас судалсан судалгаа харьцангуй цөөн тул аксеологийг судлах тухайлсан төлөөлөгчийн байр суурин дээр үнэлэх хэрэгцээ шаардлага, үүсэж байна. Тус өгүүлэлд Монгол хэлний зарим зүйр цэцэн үгсийг Гартманы “сайн” үнэлэмжийн хэлбэр болох систематик, экстринсик, интринсик үнэлэмж гэж томъёолсон зарчмын дагуу судалсан болно. Ингэхдээ герменевтик тайлбарлахуйн арга, задлах, нэгтгэн дүгнэх аргыг ашиглав. Гартманы “сайн” үнэлэмжийн хэлбэрийг тодорхойлох зарчмын дагуу монгол хэлний зүйр цэцэн үгс дэх үнэлэмж, үүний дотор “сайн”-ы хэлбэрийг илрүүлэхэд монгол зүйр цэцэн үгс өргөн утгатай, нэг цогц зүйр үгс Гартманы үнэлэмжийн бүх хэлбэрээр тайлбарлагдах боломжтой гэж дүгнэхэд хүрэв.

Түлхүүр үг: Зүйр цэцэн үгс, сайн, утга зүйн судалгаа, систематик үнэлэмж, экстринсик үнэлэмж, интринсик үнэлэмж

1. Оршил

Зүйр цэцэн үгс Монголын гүн ухааны охь болох нь: Монголын гүн ухаан гэж юу болох, ямар онцлогтой болох талаар судлаач, философичид олон ишт хувилбараар тайлбарласаар ирсэн. Зарим нь монголд гүн ухаан үгүй, буддын гүн ухааныг өөриймшүүлсэн гэх хандлагатай байдаг бол зарим нь монголчууд өөрсдийн гүн ухаантай үүнийхээ ач буянаар монгол өнөөг хүртэл оршин тогтносоор ирсэн тухай ч өгүүлдэг. Өрнийн соёл, шинжлэх ухааны гүн нөлөөний үр дүнгээр монголын сэтгэлгээ, уламжлалт арга ухааныг тайлан учирлахыг хичээсэн оролдлогууд тоймгүй.

Юутай ч бид өөрийн гэсэн өвөрмөц гүн ухааны сэтгэлгээтэйн дээр тэдгээрийг бид дотроосоо буюу бидний сэтгэлгээний тод илрэл болсон “ардын”, уламжлалт аман зохиол, үлгэр домог, яруу найраг, магтаал, туульс зэргээс хайн шинжилвэл лавтай олно. Үүний нэг тод жишээ бол монгол ардын зүйр цэцэн үгс юм. Ийн гүн ухааны учгийг эрж ядахдаа бид монгол хэл, монгол сэтгэлгээн

дээр суурилан эрэлхийлбэл зүйтэй гэж үзсэн. Ингэснээр өрнийн гүн ухааны арга зам, үзэл онол дээр ялгаа нь тодоос тод ялгаран гарах нь магад.

2. Судлагдсан байдлын тойм

“Зүйр цэцэн үг нь ард түмний гүн ухаан, оюун сэтгэлгээ, аж төрөхүйн үзэл, ёс суртахуун, хэв заншлын хэмжээг илтгэж, байгаль нийгмийн үзэгдлийг шинжлэн үзсэнээрээ танин мэдэхүй, гоо сайхны шилжишгүй ач холбогдолтой” (Академи, 2002), “Монгол ардын зүйр цэцэн үгэнд монгол үндэстний оюун ухаан, амьдралын сургаал үг, ёс заншил их орсон байдаг” (Ньми, 2011). “Зүйр цэцэн үг бол хүн ардын мянга мянган жилийн турш амьдралын туршлагаар нотлогдсон байгалийн үзэгдэл, нийгмийн амьдрал, аж төрөх ёсны тухай чин үнэнийг уран яруу, утга төгс, товч хураангуй сургамжлан өгүүлэх хэлбэр юм” (Улыкпан, 2017), “..., ардын зүйр, цэцэн үг нь сургаал санамжийн утгыг агуулснаас гадна манай ард түмний түүхт хүсэл эрмэлзэл, хэв заншлыг тодхон тусгасан байдгаараа түүх судлалын гүнзгий ач холбогдолтой юм” (Монгол ардын зүйр үг, 1959), “Ихэнх зүйр үгс болон хэлцүүд хүний үнэт зүйлс, ойлголт болон ертөнцийг үзэх үзлийг илэрхийлж байдаг ч тэдгээрийн зарим нь тухайн ард түмэн угсаатны ой санамж, амьдралын замнал, оюун ухаан, түүх, соёл зэрэгтэй зохицолт холбоотой байдаг. Угсаатны ой санамж гэдэг бол урт удаан хугацааны туршид хуримтлагдсан, тухайн угсаатанд хамаарах соёл, амьдрал, үнэт зүйлс болон ёс суртахууны онцлогийг хэлнэ” (Gulipa Madmarova, 2021, p. 634) хэмээн судлаачид онцолж зүйр үгийг судлах өргөн боломж буйг заажээ. Иймийн тул зүйр үгийн утгыг тайлах болон түүний гүн ухааны утга агуулгыг илрүүлэх бүрэн боломжтойг судлаачид онцолсныг үндэс болгосон бөгөөд философийн салбар ухаан болсон үнэлэмжийн онолын арга зүйгээр түүний цаад утга, ач холбогдлыг үнэлэх, үнэт зүйлийн агуулгыг илрүүлэхийг зорьсон.

Монголын философийн түүх бүтээлд “Зан суртахууны үнэт чанарыг илэрхийлэн тусгасан товч, оновчтой мэргэн цэцэн зүйр үг, оньсого, таавар, ёгтлол, ерөөл, магтаал, дуу, урт богино үлгэр, домог тууль арвин их баялаг бөгөөд хийсвэрлэл, гүн ухаанчлал сайтай байсныг онцлон өргөж дүгнэх ёстой. Чингэхдээ цээжлэхэд дөхмийг бодож шүлгээр, санаа эс гээгдэхийг чухалчилж илүү дутуугүй оносон үгээр, ой ухаанд багтахыг харгалзаж урнаар, утга эрхэмлэж гүн ухаанчаар, нууцлалыг харгалзаж амаар, бат үлдцийг бодож баримт бичгээр сэцлэн илэрхийлж байжээ (Лхагвасүрэн, 2000, хууд. 174)” гэсэн нь зүйр үгийн судлагдахуйц боломжийг тоочин илэрхийлсэн хэрэг.

Судлаач И.Бүрэн-Өлзий “Зүйр цэцэн үгсийн ертөнцийг үзэхүйн утга холбогдол” сэдэвт бүтээлдээ зүйр цэцэн үгийн гүн ухааны утгыг эпистемологи, онтологи, ёс зүйн болон дорнын арга билгийн сэтгэлгээний үүднээс задлан шинжилж “Зүйр цэцэн үг нь бүтцийн хувьд агуулга, хэллэгийн нэгдэлд хураангуйлагдан юмсын түгээмэл, дотоод мөн чанарыг гүн гүнзгий тусгасан бөгөөд үүгээрээ хүний амьдрал үйл ажиллагааны удирдлага болж байдаг гүн ухааны учир ёс бүхий үгийн цомнол, бодрол мөн” (Бүрэн-Өлзий, 2009) хэмээн тодорхойлжээ.

3. Зүйр цэцэн үгс нь үнэлэмжийн судлагдахуун болох нь:

Бид өдөр тутмын үйлдэл, оюун бодол, алив зүйлд ухамсарласан болон ухамсарлаагүй байдлаар хандаж, сонголт, дүгнэлт хийж байдаг. Бидний сонголт, шийдвэрийн ард үнэлэмж ихээхэн нөлөөтэйгөөр оршино. Өөрөөр хэлбэл бидний өдөр тутмын яриа, байгалийн юмсыг тайлбарлах, ухаарах гэсэн оролдлого бүгдийн суурин дээр, түүний ард үнэлэмж гол тулгуур болж байдаг. Үнэлэмжийн тухай судалгаа философийн хүрээнд хийгддэг бөгөөд энэ утгаар нь аксеологи гэж нэрлэдэг. Философийн түүхэнд үнэлэмж энэ философи дахь ёс зүй, гоо зүй, шашин судлал гэх олон салбарын зангилаан дээр өрнөж, хөгжиж, уг үнэлэмжийн мөн чанарыг гаргах аваас тэдгээр салбар ухааны үндсэн асуудал, уг учгийг нээх боломжтой тухай нэлээдгүй сэтгэгчид тэмдэглэж

үлдээсэн. XIX зууны дунд үеэс үнэлэмжийн онол буюу аксеологи нь философийн биеэ даасан салбар ухаан болжээ (Каган, 1997).

Америкийн философич Р.С.Гартман үнэлэмжийн асуудалд ихээхэн анхаарал хандуулж философийн түүхэнд үнэлэмжийн тухай асуудалд хэрхэн хандаж байсныг шинжлэн үзээд үнэлэмжийн хамгийн цөм асуудал бол “сайн” (Edwards, 2010)-ыг илрүүлэн нээх асуудал болох тухай онцолжээ. Тэрээр “сайн” ойлголтыг үнэлэмж дэх гол ойлголт болохыг илрүүлэхээс өмнө үнэлэмжийн хүрээ, хэлэнд илэрхийлэгдэх хүрээг нарийн судлав.

Р.С.Гартман хэлэнд илэрхийлэгдэх үнэлэмжийг гурван түвшинд задлан шинжилжээ. “Нэгдүгээр түвшинд хэлэн дэх эмпирик үнэлэмж буюу бидний өдөр тутмын хэлэнд илрэх үнэлэмжийн туршлага, үзэгдлийн дүрслэлийг авч үзэх; хоёрдугаар түвшинд ёс суртахууны төлөвт хэрэглэгдэх ярианы хэлэнд анализ хийх бус харин энэ төлөв байдлын талаарх ёс зүйчдийн хэрэглэх хэлэнд анализ хийх буюу товчоор хэлбэл ёс зүйд хэрэглэгддэг хэлний эмпирик байдалд анализ хийх, ингэхдээ тэрээр прагматик, семантик, логик, эпистемологийн болон математик гэсэн таван үнэлэмжийн хүрээнд задлан шинжлэв. Гуравдугаар түвшинд хэлэн дэх систематик үнэлэмжийг тодорхойлох явдал юм. Энэ нь хэлэн дэх үнэлэмжийг задлан шинжлэх бус харин тусдаа өөрийн гэсэн нэр томъёог хэрэглэж бүтэцчилэл бүхий аксеологийн формал системийг бүтээх явдал” (Hartman R., 2021, pp. 25-39) гэжээ.

Гартманаас өмнө Английн философич Ж.И Мур (G.E. Moore) үнэлэмжийн уг үндэс “сайн” болох тухай “Ёс зүйн зарчмууд” (Principia Ethica) бүтээлдээ “Сайн бол үл тодорхойлогдох, үл задлан шинжлэгдэх шинжтэй бөгөөд ёс зүйн түүхэнд үүнийг алдаатай ойлгож тодорхойлж байснаас үүдэн аз жаргал болон “зөв”-ийн тухай асуудал ганхсаар ирсэн” (Moore, 1922, p. 22) гэж дүрсэлсэн байдаг. Мурынхаар сайн бол даяар шинжтэй, ямар нэгэн материаллаг зүйлд үл оноогдох утга бүхий байдаг тухай тэмдэглэн, хүмүүс “сайн”-ыг тодорхойлохдоо энэ нь ямар нэгэн объектод оноогдож, энэ тухай тодорхойлох гэж оролдож байсан нь эцэстээ хуурмаг болдог тухай дүрсэлжээ.

Мурын сайны тухай ойлголт яг л Платоны санааны тухай онолтой адил юм. Бид санаа гэдгийг юмсын ерөнхий утга бөгөөд харин бидэнд мэдрэгдэж буй юмс тэр санааны хуулбар төдий зүйл гэж ойлгодог. Жишээ нь бид “жимс” гэдэг ойлголтод хамаарах алим, тарвас, усан үзэм зэргийг л мэдрэх болохоос биш яг жинхэнэ жимсийг үл олно. Энэ бүгдийн ард “жимс” гэсэн ерөнхий ойлголт байгааг ухаарах нь зүйтэйг Платон онцолдог.

Гартманы хувьд тэрээр сайныг тодорхойлж чадсан гэдэг. Тэрээр “сайн бол юмсын сэтгэл ханамжтай байдал” (Edwards, 2010, p. 5) гэжээ. “Сайн” нь түүний хувьд системлэг, интринсик, экстринсик гэсэн гурван агуулгаар үнэлэмжийн голлох бүрдэл болж байдаг тухай үзжээ. Гартман хэлэнд үнэлэмж агуулагдаж байдаг бөгөөд “өнөө цагт үнэлэмжгүй хэл, шинжлэх ухааны хэл гэж нэрлэгдэх математик, тоо гэх мэт оршин байна. Үүнээс илүү үнэлэмжийн хэлний олон хувилбарууд оршин байна” (Hartman, 2002, p. 25) гэж дүгнэн, хэлэнд буй үнэлэмжийн утгыг тайлах явдлыг онцолж байв.

Гартман үнэлэмж дэх гол тулгуур ухагдахуун болох “сайн”-ы тухай задлан шинжилж, энэ ойлголтын агуулга болон хамаарагдах хүрээг цэгцлэх, ингэхдээ “сайн”-ы хэлбэрийг тодруулан илэрхийлэх замаар судалгааг өрнүүлжээ. Тэрээр “сайн”, “муу” ойлголтууд ёс суртахууны ойлголт гэж ерөнхий ойлгогдох боловч үүнийг илүү өргөн хүрээгээр авч үзэх нь ёс суртахууны зааг хязгаараас хэтэрсэн буюу өөрөөр хэлбэл үнэлэмжийн сайны хэлбэрийг тодорхойлох боломжтойг (Edwards, 2010, p. 27) онцлов. Гартман “сайн” үнэлэмжийн хэлбэр болох систематик, экстринсик, интринсик үнэлэмжийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

1. *Систематик үнэлэмжийн объект* болох үзэл санаа, ойлголт, ертөнцийн, оюуны, аман хэллэгийн, эсвэл концептуал шинжийг агуулсан ойлголтууд багтана. Тэдгээр нь маш энгийн ч

бүгдийг нь авч үзвэл сэтгэлгээний нэлээдгүй бүтэц, үйлдэл, үр дүн шаардсан магадгүй философийн, хуулийн, теологийн, түүхийн, математикийн, логикийн, физикийн, химийн, биологийн гэх мэт бүгд л нийгмийн, хэлбэрийн, байгалийн шинжлэх ухааны санаанууд юм.

2. *Экстринсик үнэлэмжийн объект* болох бодит болон боломжит хэрэглэгдэх ахуйн эд зүйлс, үйл явц, өөрөөр хэлбэл өдөр тутмын амьдралын мэдрэхүйн ертөнцийн хүрээн дэх үйл ажиллагааг багтаан үздэг. Ийм объектууд бидний мэдрэхүйн туршлагын өдөр тутмын амьдралд нийтлэг байдаг зүйлийн төлөөлөл. Эдгээргүйгээр амьдрал уйтгартай, оршин тогтноход боломжгүй зүйлсийг ч хамааруулах бөгөөд амьдралыг таатай, хөгжилтэй байлгахад чухал зүйлс. Бид үнэлэмжийн физик зүйлсийн төлөө ажиллаж, зүтгэж, “амьдралын дээд хэм стандарт”-ыг материаллаг байдлаар төсөөлдөг. Экстринсик үнэлэмж голдуу “ашигтай, хэрэгтэй зүйлс”-ээр тодорхойлогддог.

3. *Интринсик үнэлэмжийн объект* болох өөрөө өөртөө төгсгөлт ахуй, дотооддоо оршигч, өөрөөр хэлбэл хүн, ухамсарт оршихуй, хувь хүний өөр хоорондын холбоос болох ахуйг үүнд багтаан үзсэн. Бид хүнийг өгүүлэх олон арга замтай, хүнийг нэрлэх, төлөөлөхдөө ч олон үгсийг ашигладаг. Өргөн утгаараа эсвэл аналогич утгаараа зарим үгс амьтадыг ч нэрлэдэг. Бидэнд чухал хэн нэгэн, эцэг эх, хүүхэд, амраг, найз нөхөд, ах дүүгийн тухай бодох үед бидэнд дотоод нандин холбоо, нөлөө, хайр сэтгэл (хайр сэтгэл) чухал болж ирнэ. (Edwards, 2010, pp. 30-31). Ийм агуулгаар Гартман “сайн”-ы үнэлэмжийн хэлбэрийг тодорхойлох боломжийг гаргажээ.

Зүйр цэцэн үгийн утга агуулга, илэрхийлж буй санааг үнэлэмжийн үүднээс судлан тайлбарласан судалгааг монголд эрдэмтэн Ш.Гаадамба, Х.Сампилдэндэв нар “Монгол ардын аман зохиол” бүтээлдээ тод тусган, зүйр цэцэн үгсийг ангилжээ. Эдгээр нь

- Нийгмийн ахуйд холбогдох
- Нийгмийн ухамсарт холбогдох (Гаадамба, 1988) гэж хуваагаад түүнээ дотор нь “сэдэв агуулга буюу гаргаж хэлэх утга санаагаар” нь:

А. Нийгмийн ахуйд холбогдох зүйр цэцэн үгийн ангилалд хүн ба түүний элдэв шинж чанар, хүний аж төрөл, ажил хөдөлмөр, хувийн болон нийгмийн өмч, нийгмийн ахуй хэв ёстой холбоотой хэллэгийг

Б. Нийгмийн ухамсрын холбогдолтой зүйр цэцэн үгийн ангилалд хүний сэтгэл оюун, хүмүүжил ёс суртахуун, нийгэм улс төр, шашин шүтлэг, гүн ухаан болон бусад зүйлийн холбогдолтой хэллэгийг

В. Бусад зүйл буюу мэргэн үгс гэсэн ангилалд мэргэн үгийг дотор нь оновчтой мэргэн үг, уран дүрслэг мэргэн үг (Гаадамба, 1988, хууд. 183) гэж тус тус ангилсан байна.

4. Үнэлэмж дэх “сайн”-ы утга Монгол зүйр үгсэд:

Гартман болон Гаадамба нарын үнэлэмжийн талаарх ангилал болон ерөнхий сайны талаарх хэлбэрийг иш үндэс болгон зүйр үгсийн мөн чанарыг эдгээр хоёр төлөөлөгчдийн үнэлэмж дэх “сайн”-ы хэлбэрийн агуулгаар шинжлэн үзье.

Р.С.Гартманы “сайн” гэж юу болохыг тайлбарлах үндсийг үндэс болгон монгол ардын зүйр үгс дэх “сайн” илэрхийлсэн утгыг илрүүлэн гаргаж ирэх боломж буй. Жишээлбэл: “*А үсэг эрдмийн дээж, Аяга цай идээний дээж*” (Академи, 2002, хууд. 23) зүйр үгэнд “А” үсэг, түүнийг сурахуйн ач холбогдол, “А” үсэг бол алив юмсын танин мэдэхүйн эхлэл болох тухай утгыг илэрхийлэв. “А” үсэг цагаан толгойн эхлэл буюу алив ойлголтын дүрсийг илэрхийлэхэд, ертөнцийн учир шалтгааныг хүн тэмдгээр илэрхийлэх мөн чанар юм. Мөн “*Алт мөнгийг уул мэт овооловч А үсэг сурсанд хүрэхгүй*” зүйр үгэнд ийн өгүүлэх утга нь “*Мэргэн хүнд мэдлэг эрдэм, мунхаг хүнд эд эрдэнэ*” зүй үгэнд Гартманы “сайн” үнэлэмжийн зарчмын дагуу, энэ нь систематик үнэлэмжид хамаарах хэлбэр болно. “Мэргэн байх” утга нь мэргэн харвах онох гэсэн үйлийн утгаар бус цэцэн

мэргэний утга, эрдэм мэдлэгтэйн, үүнийг эзэмшихийн утга, Монголчуудын эрдэм ном, цэцэн ухааныг дээдлэх, Монгол хүний “сайн”-ы хэлбэрийг илэрхийлсэн төсөөлөл болно.

Монголчууд ертөнц, түүний бүрдэл, алив бодисын мөн чанарыг сайтар мэддэг, тэдгээр юмсын сайн байх хэлбэрийг ухаарсан тухай өгүүлэх нэгэн зүйр үгийн жишээ нь “*Зэсийн сайн нь зэвэрдэггүй, зээ нагац хоёр марталцдаггүй*” Зэс бол байгаль дээрх нэгэн элемент бөгөөд алив метал дундаас үл зэврэх буюу “сайн метал, зэс”-ийн хэлбэр нь түүний хэв шинж, найрлагаа үл алдах утга болох үл зэврэх утгаар илэрхийлжээ. Бид зэс гэх элементийг танин мэдэхийн тулд түүний найрлага, орц гэх мэт түүний тухай аяндаа буй болдог биш, хичээл зүтгэл, системлэг байдал, зориудын оролдлогын дүнд зэсийн талаарх мэдлэгийг бий болгодог. Иймээс энэ болон ийм шинж бүхий зүйр үгийн үнэлэмж нь системлэг үнэлэмжийн төрөлд хамаарах нь зүйн хэрэг. Гартманы экстринсик сайн үнэлэмжийн жишээ Монгол зүйр үгэнд арвин буужээ. “Угаасан ус рашаан, унасан шороо алт” зүйр үгэнд “Ус” бол бидний амьдралд зайлшгүй хэрэгтэй ч хамгийн чухал, “сайн” ус бол тэр хүний төрсөн даруйд угааж цэвэрлэсэн тэр төрсөн газар оронд байдаг ус, энэ усны сайн шинж бол монголчуудын “сайн” усны зэрэглэл шинжтэй илэрхийлэх, рашаан, булаг, эрдэнэ, шалбааг, цөөрөм, хар ус гэх мэт усны зэрэглэлүүдээс “рашаан” буюу хамгийн “сайн” цэвэр, ариун ус гэсэн утгыг илэрхийлжээ. Усны бол бидний оршин байхад чухал зүйл тул экстринсик сайн үнэлэмжийн ангилалд хамаарагдана. Мөн “Унасан шороо бол алт” зүйр үгийн үнэлэмжит утга нь хүн бүр төрсөн ямар нэгэн орон газартай бөгөөд амьдарч буй газар орон, өөр бусад газар орноос хамгийн сайн газар бол тэр хүний төрсөн газар юм. Түүний хамгийн чухал, “сайн” утгыг илэрхийлэх арга нь “алт”-тай зүйрлэж буй хэлбэр. Эд баялгийн хамгийн дээд нь алтаар биеждэг нийтлэг сэтгэлгээнд жишихүйц утга “төрсөн газар”-ийн үнэ цэнэ, үнэт зүйлсийг дүрсэлсэн нь экстринсик сайн үнэлэмжийн жишээ юм. Түүнчлэн экстринсик үнэлэмжийн болон нийгэм ахуйн шинжтэй сайныг илэрхийлсэн үнэлэмжийн жишээ зүйр үг бол “*Морь таргаар, хүн хувцсаар*”. Үүнээс “сайн” мориний хэлбэр, сайн хүний хэлбэрийг ухан гаргах, тэдгээрт нийцэх сайн үнэлэмжийн утгыг илэрхийлж болно. “*Морь таргаар*” зүйр үг нь аливаа морины сайн шинж бол тарган байх, туранхай биш байх шинж. Гэвч морины тарган байх нь тухайн амьтны өөх хуримтлуулсан бие махбодын утгаас илүү тухайн амьтны хүчтэй, шандастай байх, тодруулбал “сайн” байх гэсэн утгыг илүү илэрхийлнэ. Иймдээ ч монголчууд “тарга тэвээрэг (чадал тэнхээ)” гэсэн хоршоо үгээр утга илэрхийлдэг буй. “*Хүн хувцсаар*” зүйр үгний утга, сайн үнэлэмжид хамаарах тайлбар нь “сайн хүн”-ий тухай нэгэн дүрслэлийн илэрхийлэл болно. Сайн хүнийг илэрхийлэх олон утга байх боловч нэгэн хэлбэр нь “сайн хувцас, өнгө, үзэмж, харагдах байдал”-аар дамжуулан сайн хүний нэгэн шинжийг зүйрлэжээ.

Гартманы өгүүлэх интринсик үнэлэмжийн нэгэн жишээ бол хүн хоорондын харилцаа, амраг, найз, эцэг эх, багш, шавь гэх мэт хүмүүсийн сайн харилцаа, сайн хүн байхын утга бүхий зүйр үгс бүр үүнд хамаарна. Жишээлбэл: “Сайн хүлэг замд хань, сайн хүн сэтгэлд хань” зүйр үгний “сайн хүн сэтгэлд хань” хэсэгт “сайн хүн”-ий хэлбэр, шинжийн нэгэн тал болох оюун санааны амгалан байлгахад нөлөөлөгч тэр хүн, хайр сэтгэлд үнэнч байхын мөн нэгэн хүн, амьдралын замд дэм бологч нэгэн хүн, найз, эрхэм хүн гэсэн утгаар “сэтгэлд хань” хэмээн зүйрлэжээ. Сайн хүн бол ийм байхын талаар өгүүлсэн нь өргөн утга бүхий үнэ цэнтэй бөгөөд “сайн” утгын субъектээр илэрхийлэгдэх нэгэн хэлбэр болно. Үүнийг нэг талыг илэрхийлэх өөр нэгэн зүйр бол “Сайн хүнд нөхөр олон, сайн моринд эзэн олон” (Академи, 2002) юм. “Сайн хүн”-ий нэгэн хэлбэр бол ойр дотны нийжгээд хүнээр хүрээлүүлсэн, найз нөхөд олонтой хүн, өөрөөр хэлбэл хүмүүсийн найзалж нөхөрлөхийн дэнсийг сайн байхаар тусгасан зэрэг. Нөхөрлөлийн үнэ цэнэ бол хүн хоорондын нандин хэлхээ, сайн хүн байхуйн нэгэн утга болно.

Сайн хүн болох үндсийг “хүүхэд” байхаас нь анхаарч үзэх тухай судлаач П.Эрдэнэтуяа: “Монгол хэлний зүйр үгсэд, жишээлбэл “Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа” зүйр үг нь хүүхдэд бага балчир наснаас төлөвших зан ааш, сайн хүн болоход анхаарахын чухлыг илэрхийлжээ.

Монгол хэлний ихэнх зүйр үгс таван хошуу малтай холбоотой илэрдэг. Иймээс зүйр үгс цөөн мэргэн үгээр хүмүүсийн ухаант, цэцэн байдлыг илэрхийлэн сургах хамгийн чухал арга зам...,” (Erdenetuya, 2022) гэж онцлон тэмдэглэсэн.

Түүнчлэн “сайн хүн”-ий өөр нэгэн хэлбэрийг илэрхийлсэн зүйр үг бол “*Сайн хүний нэрийг гурав худалддаг*” зүйр үг болно. Энэ зүйр үгийн экстринсик сайны үнэт зүйл нь “нэр хүнд”-тэй байх явдал болно. “Нэр хүнд” бол сайн хүний нэгэн хэлбэр бөгөөд хүн хоорондын бие биедээ сайнаар үнэлэгдсэний баталгаа, хүлээн зөвшөөрөгдсөн байдал юм.

Дүгнэлт

Гартманы үнэлэмжийн онол буюу “сайн” үнэлэмжийн арга зүйгээр монгол хэлний зарим зүйр цэцэн үгсийг жишээ болгон авч шинжлэн дараах дүгнэлтэд хүрэв.

- Монгол хэлний зүйр цэцэн үгс бол монгол сэтгэлгээ, соёл, ялангуяа “монголын” гэсэн алив зүйлсийг бүрэн дүүрэн илэрхийлдэг.
- Монголын гүн ухааны сэтгэлгээний охь, дээжийг зүйр үгсийн утга агуулгаас шүүрдэн үзэх, чингэхдээ үнэлэмжийн онолын аргаар мөшгөх, эстетик агуулга бүхий “сайхан-муухай”, этик агуулга бүхий “зөв-буруу”, онтологи агуулга бүхий “ертөнц-хүн”, шашны агуулга бүхий “буян- нүгэл” гэх мэтээр зааг ялгааг нь тодоор ялгаж, энэ бүгдийг аксеологийн хөрс суурин дээр холбох, судлан шинжлэх бүрэн боломжтой.
- Монгол хэлний зүйр цэцэн үгсийн үнэлэмжийн судалгаа нь хэл шинжлэл, соёл судлал, философи бүхий нийгэм хүмүүнлэгийн ухааны салбар дундын шинжтэй судлах боломжийг олгодог өвөрмөц судлагдахуун болно.
- Монгол хэлний зүйр цэцэн үгсийг ийн “сайн” үнэлэмжийн задлан шинжилгээ хийхэд аливаа зүйр цэцэн үгс нь Гартманы үнэлэмжийн хэлбэрээр дангаараа тайлбарлагдах бус, хослон “сайн”-ы хэлбэрт хам байдлаар тайлбарлагдах шинж ажиглагдав.

An axiological analysis of Mongolian proverbs with the concept “Goodness” in the framework of R.S.Hartman’s dimension

Erdenebat Tsendekhuu 

Ph.D, of Department of Social Sciences, School of Humanities and Social Sciences
Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia.

Purevsuren Banzragch 

MA, Lecturer of English language department, School of Humanities and Social Sciences Mongolian National
University of Education, Ulaanbaatar, Mongolia.

Abstract: The interdisciplinary nature of modern linguistic research has led to the need to consider evaluation from the point of view of not only a linguistic phenomenon but also from the point of philosophy. As a philosophical category, evaluation was already expressed in the works of ancient thinkers and philosophers but still continues to be a source of interest and attention for scientific research. The opportunity to analyze the mentality and culture of nations is oral literature, proverbs, and legends. Even though there are fluent semantic analyses of proverbs, one of the least researched issues of proverbs is axiological aspects. There has been a growing need to evaluate proverbs on axiological method by a value theory. In the article titled “An axiological analysis of Mongolian proverbs with

concepts of “goodness” in the framework of R.S. Hartman’s dimension,” some examples of Mongolian proverbs are studied according to the principles formulated by R.S. Hartman as the value form of “goodness” through systematically good, extrinsically good, and intrinsically good values. In doing so, the hermeneutics interpretation method, concept analyzing, and summarizing methods were used. According to the principle of Hartman’s identifying value of “goodness,” the characteristics of general features, plural meanings of cooperative meanings, and interdisciplinary studies were revealed in Mongolian proverbs.

Keywords: Proverbs, goodness, semantic study, systematic values, extrinsic values, intrinsic values

Ном зүй

Edwards, R. B. (2010). *The Essentials of Formal Axiology*. New York: University Press of America.

Erdenetuya, P. (2022). Comparative analysis of the concept of “child” in Mongolian and Korean expressions. *Cogent Arts & Humanities*.

Gulipa Madmarova, G. B. (2021). Representation Features in the National Cultural Content of Concepts Good and Evil. *Open Journal of Modern Linguistics*, 2021, 11, 630-639
<https://www.sc>, 630-639.

Hartman, R. (2021, October 06). *Open access*. Retrieved from <https://brill.com/>:
<https://library.oapen.org/handle/20.500.12657/50795>

Hartman, R. S. (2002). *The knowledge of good. Critique of Axiological Reasons*. Amsterdam, New York: Rodopi.

Moore, G. (1922). *Principia Ethica*. Cambridge: Cambridge at University Press.

Академи, (2002). *Монгол зүйр цэцэн үг*. Улаанбаатар: Бемби сан.

Бүрэн-Өлзий, И. (2009). *Зүйр цэцэн үгсийн ертөнцийг үзэхүйн утга, холбогдол*. Улаанбаатар: Улаанбаатар.

Гаадамба, Ш. С. (1988). *Монгол ардын аман зохиол*. Улаанбаатар: Улаанбаатар.

Каган, М. (1997). *Философская теория ценности*. 4.

Лхагвасүрэн, Г. Д. (2000). *Монголын философийн түүх*. Улаанбаатар: Улаанбаатар хэвлэх.

Ньми, М. (2011). *Монгол ардын зүйр цэцэн үгийн зүйл хуваасан бэсрэг толь*. Улаанбаатар: Соёмбо принтинг.

Улыкпан, К. (2017). *Монгол-Казак зүйр цэцэн үг*. Улаанбаатар: МУИС-ын хэвлэх үйлдвэр.

(1959). *Монгол ардын зүйр үг*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

